

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ
2026

ХУРЛЫН МАТЕРИАЛ



АГУУЛГА

Хурлын зар	03
Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа	04
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн	05
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол	06
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн	09
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	10
Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах	11
Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах	18
Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	25
Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэр танилцуулах	33
Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах	36
Саналын хуудас	38
Итгэмжлэлийн загвар	42

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх)-ыг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутаас “Тэнгэр Даатгал” ХК-ийн албан ёсны фейсбүүк хаяг болох Тэнгэр Даатгал – Tenger Daatgal (линк:<https://www.facebook.com/tengerinsurance>) сошиал хуудсаар цахим хэлбэрээр хуралдах тул Хувьцаа эзэмшигч та бүхэн идэвхтэй хуралдаа оролцоорой.

Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn сайтаар хүлээн авна.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэнэ. Үүнд:

- Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах;

Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2026 оны 03 сарын 03-ны өдөр (цаашид “Бүртгэлийн өдөр” гэх) байна.

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон Хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь Ээлжит хуралд өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200 Монгол улс хаягаар болон Тооллогын комиссоор дамжуулан Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар урьдчилан өгөх боломжтой.

Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцогч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, Гүйцэтгэх захирал биш бол хуулийн этгээдээс олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлийг заавал авчрах шаардлагатай. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минут хүртэл байна.

Ээлжит хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

№	Комиссын гишүүдийн нэрс	Утасны дугаар	Шуудангийн хаяг
1	А.Даваадорж	1800 - 1889	davaadorj.a@tengerinsurance.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 9⁰⁰-18⁰⁰ цаг Имэйл: davaadorj.a@tengerinsurance.mn

Компанийн хаяг: Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200, Монгол улс Утас: 7500-1889

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 02 сарын 13-ны өдрөөс эхлэн 03 сарын 28-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 18:00 цагийн хооронд “Тэнгэр Даатгал” ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээр очиж дараах баримт бичгүүдтэй танилцах боломжтой. Үүнд:

- 01 Хурлын зар;
- 02 Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа;
- 03 хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн;
- 04 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол;
- 05 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн;
- 06 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
- 07 Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- 08 Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 09 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 10 Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
- 11 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах;
- 12 Тогтоолын төсөл;
- 13 Саналын хуудас;
- 14 Итгэмжлэлийн загвар.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

"Тэнгэр Даатгал" ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Зохион байгуулах комиссын
дарга:

А.Даваадорж
(ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)

Зохион байгуулах комиссын
 гишүүд:

Э.Ариунзаяа
(Ахлах хуульч)

Д.Анударь
(Хууль, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн)

Т.Батмагнай
(Хуульч)

Т.Анхзаяа
(Маркетинг хариуцсан ахлах менежер)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ



2026 оны 02 сарын 11 өдөр

№ BR 26/08

Улаанбаатар хот

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дох хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон, “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4, 9.8 болон 9.11 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутаас “Тэнгэр Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк хаяг болох Тэнгэр Даатгал - Tenger Daatgal (линк <https://www.facebook.com/tengerinsurance>) сошиал хуудсаар зарлан **ХУРАЛДУУЛСУГАЙ.**
2. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmexpo.mn вэбсайтаар, мөн саналын хуудсаар тус ус дамжуулан **ХЭРЭГЖҮҮЛСҮГЭЙ.**
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг **ХЭЛЭЛЦҮҮЛСҮГЭЙ.** Үүнд:
 - 3.1. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
 - 3.2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
 - 3.3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 3.4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
 - 3.5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах;

Сити Центр 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Харилцагчийн төв: +(976) 1800-1889
Вэбсайт: www.tengerdmaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2026 оны 02 сарын 11 өдөр

№ BR 26/08

Улаанбаатар хот

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 сарын 03-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр **ХИЙЛГЭСҮГЭЙ**.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 02 сарын 16-ны өдөр болон 2026 оны 02 сарын 27-ны өдрүүдэд өдөр тутмын сонинд, Компанийн www.tengerdaatgal.mn вэбсайт болон Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар 2026 оны 02 сарын 13-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд **МЭДЭЭЛСҮГЭЙ**.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор **БАТАЛСУГАЙ**.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2025 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минут хүртэл байна.
8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2026 оны 02 сарын 13-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 02 сарын 20-ны өдрийн дотор Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Шаравпэлжээ овогтой Гантуяаг **ТОМИЛСУГАЙ**.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг Хавсралт №4-оор **БАТАЛСУГАЙ**.

Сити Центр 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Харилцагчийн төв: +(976) 1800-1889
Вэбсайт: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

 ТЭНГЭР
ДААТГАЛ

2026 оны 02 сарын 11 өдөр

№ BR 26/08

Улаанбаатар хот

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг Хавсралт №5-аар **БАТАЛСУГАЙ.**
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг Хавсралт №6-аар **БАТАЛСУГАЙ.**
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Алтангэрэл овогтой Даваадоржид **ДААЛГАСУГАЙ.**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ГАНТУЯА

Сити Центр 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Харилцагчийн төв: +(976) 1800-1889
Вэбсайт: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ



2026 оны 02 сарын 11 өдөр

№ BR 26/09

Улаанбаатар хот

"ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тооллогын комисс томилох тухай

"Тэнгэр Даатгал" ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Тэнгэр Даатгал" ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй **БАЙГУУЛСУГАЙ:**

Комиссын дарга: Э.Ариунзаяа (Ахлах хуульч)

Гишүүн: Д.Анударь (Хууль, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн)

2. Тооллогын комиссын дарга (Э.Ариунзаяа)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг **ДААЛГАСУГАЙ**. Үүнд:

- a) Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
- b) Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
- c) Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
- d) Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
- e) Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;
- f) Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай Тооллогын комиссын шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;
- g) Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ГАНТУЯА

Сити Центр 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Харилцагчийн төв: +(976) 1800-1889
Вэбсайт: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

ХУГАЦАА	ХӨТӨЛБӨР	ХАРИУЦАГЧ
14:00 - 14:10	Хурлын ирц бүртгэх	Тооллогын комисс
14:10 - 14:15	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс
14:15 – 14:20	Хурлын дэгийг танилцуулна	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
14:20 - 14:25	Хурлын дарга хурлыг нээж үг хэлнэ	Хурлын дарга /Ш.Гантуяа/
14:25 - 14:35	Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баянмөнх/
14:35 - 14:40	Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баянмөнх/
14:40 - 15:00	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Даваадорж/
	Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Даваадорж/
14:40 - 15:00	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Даваадорж/
	15:00 - 15:20	Асуулт хариулт
15:20 - 15:25	Санал хураалт	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баянмөнх/
15:25 – 15:40	Хурлын завсарлага, санал тоолох	Тооллогын комисс
15:40 – 15:50	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс
15:50 - 16:00	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	Тооллогын комисс
16:00 - 16:10	Хурлын дарга хурлыг хааж үг хэлнэ	Хурлын дарга /Ш.Гантуяа/

КОМПАНИЙН 2025 ОНЫ
БИЗНЕСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тэнгэр Даатгал ХК-ийн цэвэр хураамжийн орлого 2025 оны байдлаар 22.4 тэрбум төгрөгт хүрч 2020 оноос хойш жил бүр дунджаар 28 хувийн тогтвортой өсөлтийг үзүүлсэн байна.

2023 оноос эхлэн компанийн үйл ажиллагааг үр ашигтай бүтээгдэхүүн болон оновчтой зах зээлд чиглүүлснээр бизнесийн тогтвортой өсөлтийг хангаж, улмаар зах зээлд эзлэх байр суурь хэвээр хадгалагдаж байна.

ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГО:


/тэрбум төгрөг/



Цэвэр хураамжийн орлогын 64%-ийг Авто тээврийн хэрэгслийн даатгал, 15%-ийг Хөрөнгийн даатгал, 12%-ийг Гэнэтийн осол, эмчилгээний даатгал тус тус бүрдүүлж байна.

ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ:

/БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР/



ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НӨХӨН ТӨЛБӨР


Тэнгэр Даатгал ХК нь 2025 оны байдлаар нийт 6.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны оргил түвшнээс буурсан боловч түүхэн дундаж түвшнээс өндөр хэвээр байна.

Энэхүү бууралт нь сөрөг үзэгдэл бус бөгөөд компанийн эрсдэлийн удирдлага, нөхөн төлбөрийн зохицуулалтын үр дүнд юм. Үүний үр дүнд компанийн санхүүгийн тогтвортой байдал хадгалагдаж байна.

Мөн Тэнгэр Даатгал ХК-ийн нөөц сангийн үзүүлэлт 2023 оноос хойш тогтвортой өсөлттэй байна. Энэ нь урт хугацааны нөхөн төлбөрийн чадвар, харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ найдвартай биелүүлэх санхүүгийн баталгааг илэрхийлж байна.


НӨХӨН ТӨЛБӨР:

/тэрбум төгрөг/



НӨӨЦ САН:

/тэрбум төгрөг/



Нийт нөхөн төлбөрийн 67%-ийг авто тээврийн хэрэгслийн даатгалд олгосон байна. Тэнгэр даатгал нь харилцагчаас ирүүлсэн 100 хүсэлт тутмын 98 хувьд нөхөн төлбөрийг шийдвэрлэн олгож, харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ шуурхай, найдвартай биелүүлж, салбартаа тэргүүлсээр байна.

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2025 онд хөрөнгө оруулалтын багц 60.8 тэрбум төгрөгт хүрснээр хөрөнгө оруулалтын ашиг өмнөх оноос 18.3%-иар өсөж, хөрөнгө оруулалтын дундаж өгөөж 16.7% болсон байна.

Даатгалын үйл ажиллагааны ашиг өмнөх оноос 174%-иар өсөж, 3.6 тэрбум төгрөг хүрсэн нь цэвэр ашиг 47.4%-иар өсөхөд нөлөөлсөн байна.

САЯҢ	2023Q4	2024Q4	2025Q4	YOY
Даатгалын үйл ажиллагааны ашиг	1,447	1,336	3,663	174%
Хөрөнгө оруулалтын ашиг	3,710	5,830	6,897	18.3%
Цэвэр ашиг	5,157	7,166	10,560	47.4%
Өөрийн хөрөнгийн өгөөж	29.7%	25.9%	28.1%	8.5%
Хөрөнгө оруулалтын өгөөж	15.9%	15.0%	16.7%	11.3%
Төлбөрийн чадварын түвшин	II	II	II	
Хохирлын харьцаа (сан орсон)	27.9%	40.1%	31.1%	-22.4%
Зардлын харьцаа	58.5%	55.3%	56.7%	2.5%
Нийлмэл харьцаа	86.4%	95.4%	87.8%	-8.0%
Нийт хөрөнгө	36,327	56,003	75,555	34.9%
Хөрөнгө оруулалтын дүн	30,079	47,457	60,816	28.1%


ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АШИГТ АЖИЛЛАГАА


Тэнгэр Даатгал ХК-ийн цэвэр ашиг 2020 оноос 2025 он хүртэл тогтмол ашигтай ажилласан ба 2025 онд 10.6 тэрбум төгрөгт хүрснээр сүүлийн таван жилийн хугацаанд цэвэр ашиг даруй 6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Энэ өсөлт нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах стратеги, үр ашигтай бүтээгдэхүүний бодлого болон хөрөнгө оруулалтын оновчтой багц бүрдүүлж ажилласны үр дүн юм.

ЦЭВЭР АШИГ:
/тэрбум төгрөг/



ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ:




НИЙТ ХӨРӨНГӨ


Тэнгэр Даатгал ХК-ийн нийт хөрөнгө тогтмол өссөн ба 2025 онд 75.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 35 хувиар өссөн байна.

Энэхүү өсөлт нь IPO-гийн үр дүнд хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдсэнтэй уялдаатай бөгөөд компанийн санхүүгийн суурь бэхжиж, өсөлтийн боломжуудыг нэмэгдүүлснийг харуулж байна.

НИЙТ ХӨРӨНГӨ:
/тэрбум төгрөг/



МӨНГӨН ХӨРӨНГӨ:
/тэрбум төгрөг/




ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Тэнгэр Даатгалын 2025 оны цэвэр ашгийн 82 хувийг хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлж байгаа нь компанийн активын удирдлага үр ашигтай байгааг харуулж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО:


/тэрбум төгрөг/



ХОСОЛСОН ХАРЬЦАА

Хосолсон харьцаа гэдэг нь зардлын харьцаа болон хохирлын харьцааны нийлбэрийг илэрхийлдэг ба 2025 онд 88 хувьтай гарсан байна. Энэ нь хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтыг зөв удирдан ажилласны үр дүн юм.

ХОСОЛСОН ХАРЬЦАА :



ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Хөрөнгө оруулагч хувьцаанаас хоёр төрлийн өгөөж авах боломжтой. Нэгдүгээрт, ханш өсөх үед капиталын ашиг хүртэнэ. Хоёрдугаарт, компанийн ашигт ажиллагаанаас хамааран ногдол ашиг хэлбэрээр тогтмол мөнгөн урсгал авах боломж бүрддэг.

Тэнгэр Даатгал ХК-ийн хувьцааны ханш 2025.12.31-ний өдрийн байдлаар 882.9₮ байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2%-иар буурсан үзүүлэлттэй байна.

2025 оны цэвэр ашгаас 65%-ийг хуваарилах буюу нэгж хувьцаанд 114.4 төгрөг ногдож байна. Ногдол ашгийн өгөөжийг 2025.12.31-ний өдрийн хаалтын ханшид үндэслэн тооцоход 12.9%-тай байгаа нь зах зээлийн дунджаас харьцангуй өндөр байна.

КОМПАНИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН
ХАРААТ БУС АУДИТЫН
БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчид

Аудиторын дүгнэлт

Бид Тэнгэр Даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тоочоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлангын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв тогилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлангын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлангуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлангуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлангууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохиистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байх болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохиистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохиистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадмажид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйцэтгэж, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:



УНАРАНДЭЛГЭР
Аудитор

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2025	2024
Даатгалын орлого	26,645,614	17,554,215
Даатгалын үйлчилгээний зардал	(10,754,868)	(11,244,971)
Даатгалын үйлчилгээний үр дүн	15,890,746	6,309,244
Давхар даатгалын орлого / (хураамжийн төлөлт)	(5,453,651)	385,936
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	991,422	1,481,987
Давхар даатгалын цэвэр үр дүн	(4,462,229)	1,867,923
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн	11,428,517	8,177,167
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүний орлого	7,484,148	4,937,142
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз	1,195,099	1,817,093
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз	-	-
Санхүүгийн хөрөнгө, гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өөрчлөлтөөс үүссэн олз, гарз (үнэ цэнийн бууралтын буцаалтыг оруулсан)	2,274	(376,481)
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	8,681,521	6,377,754
Бусад олз	110,230	203,680
Бусад үйл ажиллагааны зардал	(7,653,283)	(6,657,060)
Бусад санхүүгийн зардал	(793,548)	(12,140)
Татварын өмнөх ашиг	11,773,437	8,089,401
Орлогын албан татварын зардал	(1,212,815)	(923,645)
Тайлант жилийн цэвэр ашиг	10,560,622	7,165,756
Бусад дэлгэрэнгүй алдагдал	(144,469)	(141,900)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	10,416,153	7,023,856

Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн. Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2025.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,250,603	97,918
Санхүүгийн хөрөнгө	60,816,242	47,457,224
Хорогдуусан өртөөр бүртгэх	50,075,728	37,162,874
Бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх	6,570,586	8,272,713
Бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх	4,169,928	2,021,637
Даатгалын гэрээний хөрөнгө	2,837,088	2,131,854
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	83,941	106,456
Авлага	70,597	107,598
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	560,562	316,214
Бараа материал	107,490	57,372
Үндсэн хөрөнгө	2,323,937	2,403,666
Ашиглах эрхтэй хөрөнгө	245,556	168,408
Биет бус хөрөнгө	39,844	47,813
Нийт хөрөнгө	<u>72,335,860</u>	<u>52,894,523</u>
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын гэрээний өр төлбөр	15,754,217	13,724,634
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	2,177,588	425,827
Дансны ба бусад өр төлбөр	1,199,290	1,027,894
Орлогын албан татварын өр төлбөр	189,707	127,790
Хойшлогдсон татварын өр төлбөр	399,422	183,533
Зээлийн өр төлбөр	8,686,306	-
Түрээсийн өр төлбөр	272,348	136,816
Нийт өр төлбөр	<u>28,678,878</u>	<u>15,626,494</u>
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	6,000,000	6,000,000
Нэмж төлөгдсөн капитал	6,480,250	6,480,250
Тусгай нөөц сан	1,388,027	1,388,027
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	1,122,806	1,122,806
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	(243,952)	(99,483)
Хуримтлагдсан ашиг	28,909,851	22,376,429
Эздийн өмч	<u>43,656,982</u>	<u>37,268,029</u>
Нийт эздийн өмч ба өр төлбөр	<u>72,335,860</u>	<u>52,894,523</u>

Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Тусгай нөөц сан	Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хуримтлагдсан ашиг	Нийт
2024 оны 1 сарын 1-ээрх	5,000,000	130,000	1,388,027	42,417	1,122,806	15,210,673	22,893,923
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	(141,900)	-	7,165,756	7,023,856
Эздийн өмчийн өөрчлөлт	1,000,000	6,350,250	-	-	-	-	7,350,250
Зарласан ногдог ашиг	-	-	-	-	-	-	-
2024 оны 12 сарын 31-ээрх	6,000,000	6,480,250	1,388,027	(99,483)	1,122,806	22,376,429	37,268,029
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	(144,469)	-	10,560,622	10,416,153
Эздийн өмчийн өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Зарласан ногдог ашиг	-	-	-	-	-	(4,027,200)	(4,027,200)
2025 оны 12 сарын 31-ээрх	6,000,000	6,480,250	1,388,027	(243,952)	1,122,806	28,909,851	43,656,982

Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2025	2024
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	11,773,437	8,089,402
<i>Татварын өмнөх ашгийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус тохируулгууд:</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	182,295	138,170
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	151,201	87,101
Биет бус хөрөнгийн хорогдол	7,969	7,969
Ханшийн бодит бус (олз) / гарз	468,432	2,569
Хүүний зардал	761,280	12,208
Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз	2,949	7,870
Авлагын үнэ цэнийн бууралт	(5,130)	10,871
Хүүгийн орлого	(7,484,148)	(4,937,142)
Ногдол ашгийн орлого	(189,841)	(18,015)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз	(1,195,099)	(1,817,093)
Үндсэн хөрөнгийн борлуулалтаас олсон (олз) / гарз	250	(1,235)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	4,473,595	1,582,675
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>		
Авлагын бууралт/(өсөлт)	(2,933,348)	(1,423,932)
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо болон бусад хөрөнгийн өсөлт	(251,267)	(72,400)
Хойшлогдсон даатгалын орлогын шимтгэлийн өсөлт / (бууралт)	534,050	(1,563,864)
Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц (өсөлт) / бууралт	2,897,226	(3,236,826)
Даатгалын нөөц сангийн (өсөлт) / бууралт	3,781,344	(6,173,538)
Дансны болон бусад өглөлийн өсөлт / (бууралт)	(5,851,016)	(164,873)
Үйл ажиллагаанаас олсон мөнгөн гүйлгээ	2,650,584	(11,052,758)
Төлсөн хүү	(475,064)	(12,208)
Төлсөн татвар	(935,009)	(786,134)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,240,511	(11,851,100)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(105,765)	(93,129)
Түрээсийн сайжруулалтын нэмэгдэл зарцуулсан	-	(82,034)
Үндсэн хөрөнгө борлуулснаас олсон	800	2,012
Хүлээн авсан хүүний орлого	8,126,658	4,668,273
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн	8,021,693	4,495,122
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Түрээсийн төлөлт	(272,348)	(123,918)
Хүлээн авсан ногдол ашиг	189,841	18,015
Төлсөн ногдол ашиг	(4,027,200)	-
Нэмж хувьцаа гаргаснаас олсон	-	7,350,250
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,109,707)	7,244,347
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	5,152,497	(111,631)
Ханшийн зөрүүний нөлөө	188	(2,569)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,918	212,118
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,250,603	97,918

Тодруулга "Тайлан бэлтгэх үндэслэл": Хураангуй санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн
Компанийн санхүүгийн тайлангуудаас өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН
БАТЛАХ;**



“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.ГАНТУЯА

“Тэнгэр Даатгал” ХК-ийн эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2025 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг танилцуулж байна.

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

“Тэнгэр Даатгал” ХК-ийн 2024 оны 12 сарын 05-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын №24/020 тоот тогтоолоор “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг баталсан.

“Тэнгэр Даатгал” ХК нь 2025 оны Нийт хураамжийн орлого 29.8 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 6%-иар өсөж, нийт даатгалын зах зээлийн 5.2%-ийг эзэлж байна.

Компанийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалт 66. тэрбум төгрөгт хүрч, хөрөнгө оруулалтын орлого 8.3 тэрбум төгрөг буюу салбартаа тэргүүлэгч нь байсаар байна. “Тэнгэр Даатгал” ХК нь 2025 онд нийт 3,454 даатгуулагчид нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлсэн нийт 6.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож, нэхэмжилсэн нөхөн төлбөрийн 98%-ийг шийдвэрлэсэн байна. Нөхөн төлбөр шийдвэрлэлтийн дундаж хугацаа ажлын 2.7 хоног байна.

“Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитаар олон улсын “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК ажилсан бөгөөд “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-17 / СТОУС-17/-ын дагуу үнэн, зөв бодитойгоор илэрхийлсэн гэж дүгнэсэн байна.

“Тэнгэр даатгал” ХК нь 2025 онд урт хугацааны тогтвортой хөгжлийг эрхэм болгон иргэдийн даатгал, эрсдэлийн болон эрүүл мэндийн боловсролыг дэмжсэн арга хэмжээ, төслүүдээрээ нийгэмд хувь нэмрээ оруулах гэсэн зорилгын хүрээнд компанийн нийгэмд үзүүлэх үнэ цэнийг нэмэгдүүлэн ажиллалаа.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА:

Байгаль орчин нийгэм засаглалын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж нийгэмдээ бодит хувь нэмэр, үнэ цэнийг бүтээсэн гэж дүгнэж байна.

Үүнд:

- Монгол ахан дүүстээ даатгал эрсдэлийн боловсрол олгох зорилгоор сошиал платформд суурилсан Asuuna, Edoctor төслүүдийг хэрэгжүүлж давтагдсан тоогоор 7 сая гаруй иргэнд анхан шатны эрүүл мэндийн зөвлөгөө, эрсдэлийн боловсрол олгоод байна.
- Тэнгэр төгөл төслийг 2021 онд эхлүүлж байсан бол өдгөө 1,550 гаруй мод бут сөөгтэй, зуун хувийн ургалттай 3 га газар бүхий ногоон төгөл болжээ.
- Санхүүгийн салбарын тулгуур багана болох даатгалын салбарын чадварлаг мэргэжилтэн, актуарч бэлтгэх зорилгын дор Ажлын байр Тэтгэлэгтэй хөтөлбөрийг Санхүүгийн Эдийн Засгийн Их Сургуультай хамтран хоёр дах жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.



БАЙГАЛЬ | 100%-ИЙН УРГАЛТТАЙ **ОРЧИН** | “ТЭНГЭР ТӨГӨЛ”

Тэнгэр Даатгал нь 2021 онд 20 жилийн ойгоо тохиолдуулан тогтвортой хөгжлийн зорилгоо биелүүлэх, компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газар төгөл үүсгэн байгуулж усалтын системийг шийдэж, мод тарих, арчлан ургуулах төслийг өөрийн хөрөнгөөрөө хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Өдгөө 11 нэр төрлийн 1,550 гаруй модыг зуун хувийн ургалттайгаар тариад байна. Бид 2025 оны Хүүхдийн баярын өдрийг “Тэнгэр Төгөл”-ийн модыг усалж байгальд ээлтэй, дурсамжтайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн билээ.

Мод дагаж ус, ус дагаж амьдрал гэдэг.

Тэнгэр Даатгалын хамт олон ирээдүй хойч үедээ амьсгалах цэвэр агаар, ногоон байгууламжийг үлдээх зорилго өвөрлөн “Тэнгэр Төгөл”-ийг жилээс жилд өргөжүүлж, модны ургалтад анхаарал хандуулан ажилласаар байх болно.



ASUUNA | Монгол улсын ирээдүй ӨСВӨР НАСНЫХАНДАА ЗОРИУЛАВ

Тэнгэр даатгалын зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд өсвөр насны хүүхдүүдэд зориулан “ASUUNA” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өсвөр насны хүүхдүүдийн эцэг эхтэйгээ хүртэл хуваалцаж чаддаггүй асуудлуудыг хэрхэн даван туулах талаарх зөвлөгөө, мэдээлэл өгөх суваг дутмаг байдаг.



asuuna.mn

Уг хэрэгцээ шаардлагыг үндэслэн бид 2022 оноос эхлэн 13-18 насны хүүхдүүдэд эрүүл мэнд, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн асуултад нь хариулт өгөх зорилготойгоор “ASUUNA” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүн бид давтагдсан тоогоор 315 мянган удаагийн зөвлөгөө зөвлөмжийг өсвөр насны хүүхдүүдэд хүргээд байна.

EDOCTOR

Монгол улсын анхны
ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДСЭН САН

Edoctor.mn вэбсайт нь эрүүл мэндийн зөвлөмж, өвчний мэдээлэл, шинж тэмдгийн асуулга, эмнэлэг хайх, эрүүл мэндийн тооцоолуур гэсэн үндсэн 5 цэсээс бүрддэг.

Бид өдгөө 1.5 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтаасан өргөн мэдээллийн баялаг сантай болоод байна.

Үүний үр дүнд улиралд давтагдсан байдлаар 2.91 сая удаагийн хандалттайгаар иргэдийн эрүүл мэндийн боловсролд хөрөнгө оруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлж байна.

Мөн Монголын тэргүүлэх зэргийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран Эрүүл мэндийн подкаст, 1 минут 1 асуулт, Хамгийн түгээмэл асуултууд зэрэг видео контентуудыг бэлтгэн Facebook, Instagram, Youtube зэрэг олон нийтийн сүлжээгээр цацаж олны хүртээл болгож байна.

Тус контентуудуудад Монгол Улсын болон хувийн тэргүүлэх эмнэлгүүдийн эмч мэргэжилтнүүд оролцон ард иргэдэд хамгийн түгээмэл тохиолддог өвчин эмгэгүүдийн талаар заавар зөвлөгөө өгдөг бөгөөд өдгөө зөвхөн 2025 онд давтагдсан тоогоор 7,330,902 хүнд хүрч үйлчилсэн байна.

1.5 САЯ

тогтмол уншигч

250+

өвчний дэлгэрэнгүй мэдээлэл

100+

зөвлөмж нийтлэл



ULAANBAATAR MARATHON 2025

Тэнгэр даатгалын
ЭЛЧ ТАМИРЧИД

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжихээс гадна нийтийн биеийн тамирын их үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ulaanbaatar Marathon 2025” олон улсын гүйлтэд Mongolian Elite Runners Club-ын тамирчдыг ивээн тэтгэн хамтран ажиллалаа.

Тус клубын тамирчин, марафон гүйлтийн спортын ОУХМ Ж.Олонбаяр, хэт холын марафон гүйлтийн спортын ОУХМ Б.Сарангуа нараар манлайлуулсан 32 тамирчид Тэнгэр даатгалын элч тамирчдаар гүйж амжилттай оролцсон.

“Ulaanbaatar Marathon 2025” гүйлтэд 41 улсын, 30,000 гаруй гүйгчид хамрагдсан өргөн цар хүрээтэйгээр 10 дах жилдээ зохион байгуулагдсан.



Mandal Student



MANDAL STUDENT

40 сурагчийг цалинтай ажлын байраар ханган
ТЭТГЭЛЭГ ОЛГОВ

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль болон Мандал Санхүүгийн Нэгдэл хамтран банк, санхүүгийн бакалаврын зэрэг олгох тэтгэлэгт “Mandal Student” хөтөлбөрийг 2024 оноос эхлүүлсэн нь 2 дах жилдээ амжилттай хэрэгжиж нийт 40 сурагчийг цалинтай ажлын байраар ханган, тэтгэлэг олгон ажилласан.

Тус хосолсон хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн бакалаврын зэргийг авах, багийн ажиллагаа, бүтээмжтэй, өгөгч байх чадварт давхар суралцахаас гадна ажлын туршлагатай болох боломжтой гэдгээрээ Монгол улсад анхдагч нь болж байна.

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“Тэнгэр Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 02 сарын 11-ны өдрийн ээлжит бус хурлын
26/08 тоот тогтоолын Хавсралт №4-1

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

(Тогтоолын төсөл)

2026 оны 03 сарын 28-ны өдөр

Дугаар 26/001

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дах заалтуудыг тус тус удирдлага болгон “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Ш.ГАНТУЯА

КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ ТАРААХ
ЭСЭХ ТАЛААРХ
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГАРГАСАН ШИЙДВЭР;**



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

 ТЭНГЭР
ДААТГАЛ

2026 оны 02 сарын 05 өдөр

№ BR 26/04

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6, 46.10 дугаар зүйл, "Тэнгэр Даатгал" ХК-ийн Дүрмийн 7.2 дугаар зүйл болон "Тэнгэр Даатгал" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Тэнгэр Даатгал" ХК нь 2025 онд 10.56 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 114.4 төгрөг буюу нийт 6,864,000,000.00 (зургаан тэрбум найман зуун жаран дөрвөн сая) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашгийг 2026 оны 03 сарын 31-ний өдрийн дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баянмөнх)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн энэхүү шийдвэрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баянмөнх)-д даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2026 оны 02 сарын 05-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн компанийн тухай хуулийн 80.2-р заалтыг үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ГАНТУЯА

Сити Центр 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Харилцагчийн төв: +[976] 1800-1889
Вэбсайт: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААНЫ ТОО

“Тэнгэр Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2025/12/31-ны өдрийн байдлаарх

№	ЖАГСААЛТ	ТОО ШИРХЭГ	ЭЗЭМШЛИЙН ХУВЬ
1	Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК	25,500,000	51.54%
2	Мандал Праявит Экүити хувийн ХОС ХХК	17,500,000	29.17%
3	Олон нийт	17,000,000	19.30%

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН
**2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛУУЛАХ**



ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“Тэнгэр Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 02 сарын 11-ны өдрийн ээлжит бус хурлын
26/08 тоот тогтоолын Хавсралт №4-2

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

(Тогтоолын төсөл)

2026 оны 03 сарын 28-ны өдөр

Дугаар 26/002

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дах заалтуудыг тус тус удирдлага болгон “Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай.

№	Зардлын төсөв	Нийт зардал (төгрөг)
1	ТУЗ-ийн дарга болон бусад найман гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал	600,000,000
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал	20,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	5,000,000
Нийт дүн		625,000,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Ш.ГАНТУЯА

САНАЛЫН ХУУДАС

“Тэнгэр Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 02 сарын 11-ны өдрийн ээлжит бус хурлын
26/08 тоот тогтоолын Хавсралт №3-1

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Компанийн нэр: “Тэнгэр Даатгал” ХК

Хурал хуралдах газар, огноо, цаг: 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутаас “Тэнгэр Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaqatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны тоо төрөл*энгийн*.....

№	Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно)	Хувьцаа эзэмшигчийн санал			Татгалзсан үндэслэл
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах				

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг):

Огноо: 2026 оны сарын-ны өдөр цаг минут

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

- Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
 - Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (√) тэмдэг тавина.
 - Засварласан, балласан, (√)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг хувилбарыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
 - Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг саналын хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна, эсхүл итгэмжлэлээр төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.
- Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200 Монгол улс хаягаар 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15:00 цагийн дотор ирүүлнэ үү.

САНАЛЫН ХУУДАС

3. Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргын зааврын дагуу Тооллогын комисст өөрийн бөглөсөн саналын хуудсыг өгнө.
4. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Эцэг/эхийн нэр нэр

Таны:

Эцэг/эхийн нэр нэр

Утасны дугаар

Гарын үсэг

Зөвхөн тооллогын комиссын албан хэрэгчид:

Саналын хуудсыг хүчингэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм /Үгүй

Саналын хуудсыг хүчингэйд тооцсон үндэслэл:

Саналын хуудас тоолсон өдөр, цаг: 2026 оны сар.....өдөр цаг минут

САНАЛЫН ХУУДАС

“Тэнгэр Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 02 сарын 11-ны өдрийн ээлжит бус хурлын
26/08 тоот тогтоолын Хавсралт №3-2

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Компанийн нэр: “Тэнгэр Даатгал” ХК

Хурал хуралдах газар, огноо, цаг: 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутаас “Тэнгэр Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaqal хаягаар дамжуулан цахимаар хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны тоо төрөл*Энгийн*.....

№	Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно)	Хувьцаа эзэмшигчийн санал			Татгалзсан үндэслэл
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах				

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг):

Огноо: 2026 оны сарын-ны өдөр цаг минут

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

- Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
 - Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (✓) тэмдэг тавина.
 - Засварласан, балласан, (✓)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг хувилбарыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
 - Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг саналын хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна, эсхүл итгэмжлэлээр төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.
- Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцагч брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200 Монгол улс хаягаар 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15:00 цагийн дотор ирүүлнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа Хувьцаа

САНАЛЫН ХУУДАС

Эзэмшигчдийн ээлжит хурлын даргын зааврын дагуу Тооллогын комисст өөрийн бөглосөн саналын хуудсыг өгнө.

8. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Эцэг/эхийн нэр нэр

Таны:

Эцэг/эхийн нэр нэр

Утасны дугаар

Гарын үсэг

Зөвхөн тооллогын комиссын албан хэрэгцээнд:

Саналын хуудсыг хүчингэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм /Үгүй

Саналын хуудсыг хүчингэйд тооцсон үндэслэл:

Саналын хуудас тоолсон өдөр, цаг: 2026 оны сар.....өдөр цаг минут

ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР

“Тэнгэр Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 02 сарын 11-ны өдрийн ээлжит бус хурлын
26/08 тоот тогтоолын Хавсралт №6

2026 ОНЫ 03 САРЫН 28-НЫ ӨДРИЙН “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР

Миний бие -ны
(РД:) нь “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгө дэх нэг бүр нь төгрөгийн нэрлэсэн үнэтэй ширхэг
хувьцааг эзэмшдэг бөгөөд энэхүү итгэмжлэлээр -ны
..... (РД:)-г 2026 оны 03 сарын 28-ны өдрийн 15 цаг 00
минутаас “Тэнгэр Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/tengerinsurance>
хаягаар дамжуулан цахимаар хуралдах “Тэнгэр Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хуралд миний нэрийн өмнөөс оролцох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зард тусгасан хэлэлцэх
асуудал болон хурлаас гарах шийдвэртэй холбогдуулан доор заасны дагуу, хэрэв доор тусгайлан
тэмдэглээгүй/заагаагүй бол өөрийн зохистой гэж үзэсний дагуу санал өгөх бүрэн эрхийг олгож,
итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж байна.

№	Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно.)	Хувьцаа эзэмшигчийн санал			Татгалзсан үндэслэл
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах				

№	Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно.)	Хувьцаа эзэмшигчийн санал			Татгалзсан үндэслэл
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах				

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тэмдэг:

Итгэмжлэл олгосон огноо:

1. Хувьцаа эзэмшигч өөрийн нэр, хаяг, регистрийн дугаарыг том үсгээр бичиж оруулна уу.
2. Хувьцаа эзэмшигч өөрийн нэр дээр бүртгэлтэй, энэхүү итгэмжлэлд хамаарах хувьцааны тоог оруулна уу. Хэрэв тодорхой тоо заагаагүй бол энэхүү итгэмжлэлийг таны нэр дээрх Компанийн бүх хувьцаанд хамааруулна.
3. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, регистрийн дугаарыг оруулна уу. Нэгээс илүү итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох бол тухайн итгэмжлэлд хамаарах хувьцааны тоог оруулна уу. Хэрэв аливаа нэр заагаагүй бол Хурлын дарга таны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хуралд санал өгөх болно.

ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР

4. АНХААР: Энгийн аргаар санал тоолох асуудлын хувьд л холбогдох хэсгийн “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”-ий зөвхөн аль нэгийг (✓) гэж тэмдэглэнэ үү. Аливаа тэмдэглэгээ хийгээгүй тохиолдолд таны итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн үзэмжээр Хурлаас гарах шийдвэрт санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу.

Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг итгэмжлэл дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн гарын үсэг зурж компанийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.



☎ 1800 - 1889

✉ insurance@tengerinsurance.mn

🏢 Даваа - Баасан: 08:30-19:00
Бямба, Ням: Амарна

📍 City center, 11 давхар СБД, 8-р хороо,
Улаанбаатар хот, Монгол улс